



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 4/379

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн тооцугай.
3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221810

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07
дугаар сарын 20 - ны өдрийн 1/379
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Сонгинохайрхан дүүрэг, ТОНЭ өрхийн эрүүл мэндийн төв	230/2022	3 жил	2022.07.25	2025.07.25
2.	Баянгол дүүрэг, Энхт өрхийн эрүүл мэндийн төв,	231/2022	2 жил	2022.07.08	2024.07.08
3.	Баян-Өлгий аймаг "Шипагер" өрхийн эрүүл мэндийн төв	232/2022	2 жил	2022.08.31	2024.08.31
4.	Баян-Өлгий аймаг "Улаанхус" сумын эрүүл мэндийн төв	233/2022	2 жил	2022.07.08	2024.07.08
5.	Баян-Өлгий аймаг "Цэнгэл" сумын эрүүл мэндийн төв	234/2022	2 жил	2022.07.08	2024.07.08
6.	Баян-Өлгий аймаг "Нурлы" ХХК-ийн "Нурлы" эмнэлэг	235/2022	4 жил	2022.08.01	2026.08.01
7.	Баян-Өлгий аймаг "Ахсу" ХХК-ийн рашаан сувилал	236/2022	2 жил	2022.07.08	2024.07.08
8.	Өмнөговь аймаг "Сэврээ" сумын эрүүл мэндийн төв	237/2022	3 жил	2022.07.08	2025.07.08
9.	Өмнөговь аймаг "Ханбогд" сумын эрүүл мэндийн төв	238/2022	3 жил	2022.07.08	2025.07.08
10.	Өмнөговь аймаг "Булган" сумын эрүүл мэндийн төв	239/2022	2 жил	2022.07.08	2024.07.08
11.	Өмнөговь аймаг "Гурвантэс" сумын эрүүл мэндийн төв	240/2022	2 жил	2022.07.08	2024.07.08
12.	Сэлэнгэ аймаг "Сант" сумын эрүүл мэндийн төв	241/2022	1 жил	2022.07.08	2023.07.08
13.	Сэлэнгэ аймаг "Баруунбүрэн" сумын эрүүл мэндийн төв	242/2022	2 жил	2022.07.08	2024.07.08
14.	Сэлэнгэ аймаг "Цагааннуур" сумын эрүүл мэндийн төв	243/2022	2 жил	2022.07.27	2024.07.27